

Жилийн үйл ажиллагааны тайлагнал /маягт 1/	
Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 20 дугаар зүйлд Үнэт цаас гаргагчийн нийтлэг үүргийг хуульчилсан бөгөөд үнэт цаас гаргагч нь жилийн үйл ажиллагааны тайлан дараах маягтын дагуу Санхүүгийн зохицуулах хороо, арилжаа эрхлэх байгууллагад мэдээлэл ирүүлж, өөрийн цахим хуудсаар дамжуулан олон нийтэд мэдээлэл хүргэх үүрэгтэй.	
2022 оны үйл ажиллагааны тайлан	
Тайлагнах хугацаа	2022 оны 1 дүгээр сарын 01-ний өдрөөс 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдөр
Үнэт цаас гаргагчийн нэр, улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, үнэт цаасны код, утасны дугаар	Техник импорт ХК, УБГД: 9010001041 ҮЦК: 441 Утасны дугаар: (+976) 70001830,
Бүртгэлтэй арилжаа эрхлэх байгууллагын нэр	“Монголын Хөрөнгийн Бирж” ТӨХК
Бизнесийн үйл ажиллагааны салбар	Гадаад худалдаа
Жилийн эцсийн санхүүгийн тайланд аудитын дүгнэлт гаргасан СЗХ-нд бүртгэлтэй аудитын компанийн нэр, бүртгүүлсэн огноо	Лидер экаунт аудит ХХК 2022.03.27.
Үнэт цаас гаргагчийн гаргасан нийт хувьцааны тоо ширхэг	144, 675.5
Жилийн тайланг бэлтгэсэн мэргэжилтэн, хянасан албантушаалтны нэр	Бэлтгэсэн: Ерөнхий ня-бо С. Дашдулам ТУЗ-ын н.б.д О. Бүжинлхам Хянасан: Гүйцэтгэх захирал Д. Ганцэцэг
1.	Тайлант жилийн санхүүгийн тайлан /хураангуй тайлангийн үзүүлэлтийг бөглөж, санхүүгийн тайланг хавсаргана/
	Санхүүгийн байдлын үзүүлэлт Тайланг хавсаргав.
	Орлогын тайлан Тайланг хавсаргав.
	Өмчийн өөрчлөлтийн тайлан Тайланг хавсаргав.
	Мөнгөн гүйлгээний тайлан Тайланг хавсаргав.
1.1.	Жилийн санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлт

	Бидний дүгнэлтээр,Техник импорт ХК-ийн 2022 оны 12-р сарын 31-нээрх санхүүгийн байдал ба уг өдрөөр дуусгавар болсон жилийн санхүүгийн үр дүн ба өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ нь бүхий л материаллаг зүйлсийн хувьд Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв, бодитой илэрхийлэгдсэн байна.									
1.2.	Аудитын тодорхойлох захидлыг хавсаргав.									
2.	Үнэт цаас гаргагч нь тайлант хугацаанд санхүүгийн нөхцөл байдал, үйл ажиллагааны үр дүнд нөлөөлсөн хүчин зүйлс, удирдлагаас өгсөн үнэлгээ, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар товч тайлбарласан тайлан, мэдээлэл									
2.1.	Үйл ажиллагааны үр дүн /санхүүгийн харьцааны үзүүлэлтүүд/	<p>Тайлант хугацаанд: Техник импорт ХК нь 2022 оны эхний хагас жилийн байдлаар 88,951,733,717.70 тэрбум төгрөгний борлуулалт хийж, улсын төсөвт 9,129,207,200 төгрөгний татвар төлж, 3,208,742,611.27 сая төгрөг /татварын дараах ашиг/-ийн ашигтай ажилласан бол 2022 оны санхүүгийн жилд 211 тэрбум 465 сая төгрөгийн борлуулалтын орлого олсон нь өмнөх оноос 69 тэрбум 328,9 сая төгрөгөөр буюу 49%-иар өссөн байна.</p> <p>Борлуулсан бүтээгдэхүүний өртөг 62 тэрбум 025,1 сая төгрөгөөр буюу 47%-иар өссөн нь өмнөх жилийн төвшингөөс өссөн байна. Борлуулалтаас олсон ашиг 18 тэрбум 233,4 сая төгрөг болж өмнөх оноос 7 тэрбум 303,8 төгрөгөөр буюу 67%-иар өссөн байна.</p> <p>Үндсэн бус үйл ажиллагааны орлого 713,5 сая төгрөг болж урьд оноос 14%-иар өссөн, үндсэн үйл ажиллагааны зардал 8 тэрбум 843,6 сая төгрөгт хүрч урьд оноос 29,7%-иар өссөн байна.</p> <p>Гадаад валютын ханшийн алдагдал 73,6 сая төгрөгт хүрчээ.</p> <p>Татварын өмнөх ашиг 10061,0 сая төгрөг болж өмнөх оноос 5250,2 сая төгрөгөөр өссөн.</p> <p>Улсын төсөвт ААНОАТ-т 1653,9 сая төгрөг төлөхөөр, тайлант үеийн цэвэр ашиг 8407,0 сая төгрөг болж өмнөх оноос 4 тэрбум 77,3 сая төгрөгөөр өссөн байна.</p> <p>2022 онд тус компани нь улсын төсөвт <b>14 тэрбум 993,5</b> сая төгрөгийн татвар төлжээ. Үүнд:</p> <table border="0"> <tr> <td>ААНОАТатварт</td> <td>476,1 сая төгрөг</td> </tr> <tr> <td>НӨАТатварт төгрөг</td> <td>18 тэрбум 067,7 сая төгрөг</td> </tr> <tr> <td>Гаалийн татварт төгрөг</td> <td>1 тэрбум 712,3 сая төгрөг</td> </tr> <tr> <td>НДШ</td> <td>302,2 сая төгрөг</td> </tr> </table>	ААНОАТатварт	476,1 сая төгрөг	НӨАТатварт төгрөг	18 тэрбум 067,7 сая төгрөг	Гаалийн татварт төгрөг	1 тэрбум 712,3 сая төгрөг	НДШ	302,2 сая төгрөг
ААНОАТатварт	476,1 сая төгрөг									
НӨАТатварт төгрөг	18 тэрбум 067,7 сая төгрөг									
Гаалийн татварт төгрөг	1 тэрбум 712,3 сая төгрөг									
НДШ	302,2 сая төгрөг									

Бусад татварт 163,1 сая төгрөг  
Газрын төлбөрт 43,9 сая төгрөг  
тус тус төлсөн байна.

Эргэлтийн хөрөнгө оны эцэст 86 тэрбум 674,5 сая төгрөг байна. Үүнд:

Мөнгөн хөрөнгө 1007,4 сая  
Бараа материал 14 тэрбум 425,1 сая,  
Авлага 71 тэрбум 242,0 сая  
төгрөг байна.

Дансны өглөг урьд оноос 25 тэрбум 183,8 сая төгрөгөөр нэмэгдэж 66 тэрбум 171,9 сая төгрөг болжээ. Банкны богино хугацаат зээлийн өглөг 35 тэрбум 69,3 сая төгрөг болж урьд оноос 4 тэрбум 802,8 сая төгрөгөөр өссөн байна.

Эргэлтийн хөрөнгөөр өр төлбөрөө төлөх боломж:

86 тэрбум 674,5 сая төгрөг /эргэлтийн хөрөнгө/-66 тэрбум 171,9 сая төгрөг /өр төлбөр/=20 тэрбум 502,6 сая төгрөг болж байгаа нь төлбөрийн чадвар боломжит хэмжээнд байгааг харуулж байна.

Цаашид санхүүгийн болон бусад үйл ажиллагаанд анхаарах зүйл:

- Бараа материалын нөөцийг эргэлтэнд оруулж мөнгөн эргэлтийн хөрөнгийг түргэсгэх,
- Дансны авлага 55 тэрбум 884,7 сая төгрөг байгааг анхаарч шуурхай барагдуулах арга хэмжээ авч банкны богино хугацаат зээлийн үлдэгдлийг бууруулах,
- Улирал тутам компанийн санхүүгийн тайланд эдийн засгийн дүн шинжилгээ хийж цаашид хийх ажлыг төлөвлөж ажиллах,
- Бараа, материал хариуцсан менежерүүд импортоор болон дотоодоос нийлүүлж байгаа барааны зах зээл, валютын ханшийн өөрчлөлт, эрэлт нийлүүлэлтэнд судалгаа хийж ажиллах хэрэгтэй байна.

Компанийн 2022 оны нийт борлуулалтын орлогыг өмнөх онтой харьцуулж үзэхэд:

- 2021 онд 142 тэрбум 136,5 сая төгрөг байсан бол
- 2022 онд 211 тэрбум 465, 4 сая болсон байна.

Борлуулалтаас олсон ашиг:

- 2021 онд 10 тэрбум 927,7 сая байсан бол
- 2022 онд 18 тэрбум 233,5 сая төгрөг

		<p>Татвар төлөхийн өмнөх цэвэр ашиг:</p> <ul style="list-style-type: none"> <li>• 2021 онд 4 тэрбум 810, 8 сая төгрөг байсан бол</li> <li>• 2022 онд 10 тэрбум 61 сая төгрөг болж 5 тэрбум 250,2 сая төгрөгөөр өссөн байна.</li> </ul> <p>Татварын дараахь цэвэр ашиг:</p> <ul style="list-style-type: none"> <li>• 2021 онд 4 тэрбум 329,7 сая төгрөг байсан бол</li> <li>• 2022 онд 8 тэрбум 407 сая төгрөг болж өссөн үзүүлэлттэй байна.</li> </ul>
2.2.	Хөрвөх чадвар болон санхүүгийн нөөц, боломжийн үзүүлэлт	<ol style="list-style-type: none"> <li>1. Цэвэр эргэлтийн хөрөнгө нь <math>86674,5 - 66172,0 = 20502,5</math> тэрбум төгрөг байгаа нь 2021 оноос 50,5 хувиар өссөн байна.</li> <li>2. Төлбөр түргэн гүйцэтгэх чадварын харьцаа <math>= \frac{1007,4 + 71242,0}{66172,0} = 1.1</math></li> </ol> <p>Энэхүү 1-ээс дээш үзүүлэлттэй байгаа нь компанийн төлбөрийн чадвар сайн байгааг харуулж байна.</p> <ol style="list-style-type: none"> <li>3. Эргэлтийн харьцаа нь <math>86674,5 / 66172 = 1.3</math> нь эргэлтийн хөрөнгөөрөө өр төлбөр барагдуулах чадвар сайн байгааг харуулж байна.</li> </ol>
2.3.	Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд гадаад, дотоод орчноос үзүүлж буй нөлөөлөл, үйл ажиллагаа явуулж буй салбарт эзлэх хувь, бүтээгдэхүүн, үйлчилгээний нэр төрөлд гарч буй өөрчлөлт, хөгжил дээрх өөрчлөлтөд үнэт цаас гаргагчийн зүгээс авч хэрэгжүүлэхээр төлөвлөж буй арга хэмжээний мэдээлэл	<ol style="list-style-type: none"> <li>1. Ханшийн өсөлт /доллар, юань/</li> <li>2. Импортын барааны үнийн өсөлт /мотоцикл, битум/</li> <li>3. Дотоодын бараа, материалын үнийн өсөлт /цемент/</li> <li>4. Бэлэн мөнгөний хомсдол үүссэнээс бараа материал нийлүүлэх хугацаа удааширах, хойшлогдох</li> </ol> <p>Мотоцикл, цемент, битумын борлуулалтаар дотоодын зах зээлд зохих байр суурийг эзэлдэг.</p>
2.4.	Санхүүгийн байдлын тайлангийн гадуур бүртгэгдсэн ажил, гүйлгээний талаарх дэлгэрэнгүй мэдээлэл, нягтлан бодох бүртгэлийн бодлогын мэдээлэл /off balance/	Санхүүгийн байдлын тайлангийн гадуур бүртгэгдсэн ажил, гүйлгээ байхгүй.
	Тайлант хугацаанд авсан зээлийн эргэн төлөлт болон зээлийн барьцаа, баталгааны талаарх мэдээлэл;	Зээлийн мэдээлэл: ХХБ Тайлант хугацаанд Худалдаа хөгжлийн банкнаас эргэлтийн хөрөнгийн зориулалтаар 8 тэрбум төгрөгийн зээлийг нэмэлтээр 12 сарын хугацаатай, сарын 12,8 хувийн хүүтэй авсан. Банкнаас авсан

2.5.		зээлийг зориулалтын дагуу ашиглаж зээлийн эргэн төлөлт банктай байгуулсан зээлийн гэрээний дагуу хэвийн явагдаж байна. Уг зээлтэй холбоотой ТУЗ-ын хурлын тэмдэглэл, тогтоол, банкны зээлийн болон барьцааны гэрээ, холбогдох бусад материалыг СЗХ-нд хүргүүлсэн. Зээлийн барьцаанд борлуулалтаас болон дансаар орж ирэх мөнгөн хөрөнгийг тавьж холбогдох банкны зээлийн болон барьцааны гэрээг Хорооны тодорхойлолтын дагуу харьяа улсын бүртгэлийн газарт бүртгүүлсэн.
3.	Үнэт цаас гаргагчийн тайлант хугацаанд хийгдсэн сонирхлын зөрчилтэй болон их хэмжээний хэлцлийн мэдээлэл, хэлцэл хийх ач холбогдол зорилго, сонирхлын зөрчилтэй этгээдийн талаарх мэдээлэл /тайлант хугацаанд хийгдсэн нийт сонирхлын зөрчилтэй хэлцлийн талаарх мэдээллийгтусгана/	
Тайлант хугацаанд сонирхлын зөрчилтэй хэлцэл хийгдээгүй.		
Цалин, урамшууллын мэдээлэл		
<p>Тайлант хугацаанд:</p> <ol style="list-style-type: none"> <li>1. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдэд 3 500 000 төгрөгийн цалин олгосон.</li> <li>2. Компанийн ажилтнуудад ажилласан жилийн нэмэгдлийг 2, 7 саруудад олгосон.</li> <li>3. Компанид ISO-9001-2015 чанарын удирдлагын тогтолцоог нэвтрүүлэхтэй холбогдуулан компанийн ажилтнуудын цалин, урамшууллын хэмжээг шинэчлэн баталсан.</li> </ol>		
Компанийн засаглалтай холбоотой мэдээлэл		
<p><b>Компанийн удирдлагын бүтэц</b></p> <ol style="list-style-type: none"> <li>1. Хувьцаа эзэмшигчдийн хурал</li> <li>2. Төлөөлөн удирдах зөвлөл</li> <li>3. Гүйцэтгэх удирдлага</li> </ol> <p><b>Хувьцаа эзэмшигчдийн хурал:</b>  Компанийн Дүрэмд “Компанийн эрх барих дээд байгууллага нь Хувьцаа эзэмшигчдийн хурал байна” гэж заасан.  Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөл нь Компанийн тухай хуульд заасны дагуу жил бүр санхүүгийн жил дууссанаас хойш 4 сарын дотор Хувьцаа эзэмшигчдийн хурлыг зарлан хуралдуулдаг.  Тайлант хугацаанд 2022 оны компанийн Хувьцаа эзэмшигчдийн хурлыг 2022 оны 04-р сарын 11-ний өдрийн 15 цагт компанийн “Хурлын танхим”-д хуралдуулж дараах асуудлуудыг хувьцаа эзэмшигчдэд танилцуулж хэлэлцүүлсэн. Үүнд:</p> <ol style="list-style-type: none"> <li>1. Компанийн 2021 оны үйл ажиллагааны болон жилийн эцсийн санхүүгийн тайланд ТУЗ-аас гаргасан дүгнэлт</li> <li>2. Компанийн 2021 оны үйл ажиллагааны тайлан, ногдол ашгийн тайлан</li> <li>3. Компанийн 2022 оны үйл ажиллагааны төлөвлөгөө</li> <li>4. Компанийн 2022 оны ТУЗ-ын ердийн болон хараат бус гишүүдийг сонгох</li> </ol> <p>Хувьцаа эзэмшигчдийн хуралд саналын эрхтэй нийт хувьцаа эзэмшигчдийн 97,58% нь оролцсон ба хурлаар хэлэлцэх асуудлуудын талаар хувьцаа эзэмшигчдээс саналын хуудсаар санал авахад</p>		

хурлаас гарах шийдвэр, тогтоолын төслийг хуралд оролцсон нийт хувьцаа эзэмшигчид дэмжиж 100%-ийн саналаар баталж шийдвэрлэсэн.

Компанийн 2022 оны Хувьцаа эзэмшигчдийн хурлын 2022 оны 04 сарын 11-ний өдрийн 04 тоот тогтоолын дагуу 2022 оны Хувьцаа эзэмшигчдийн хурлаас Ж. Баярсайхан, Б.Батсайхан, Б.Нарантуяа нарыг ТУЗ-ын хараат бус гишүүнээр, Д.Баяраа, Т.Тунгалаг, Г.Уран-Өлзий, С.Бүжинлхам, Э.Батболд, Ж.Уртнасан нарыг ТУЗ-ын ердийн гишүүнээр тус тус сонгож баталсан.

Компанийн 2022 оны Хувьцаа эзэмшигчдийн хурлын 2022 оны 04 сарын 11-ний өдрийн 05 тоот тогтоолын дагуу ТУЗ-ын дэргэдэх хороодыг байгуулсан. ТУЗ-ын Аудитын хорооны даргаар Ж. Баярсайхан, гишүүдээр Д.Баяраа, Б.Батсайхан нарыг, Нэр дэвшүүлэх хорооны даргаар Б.Нарантуяа, гишүүдээр Б.Батсайхан, Г.Уран-Өлзий нарыг, Цалин, урамшууллын хорооны даргаар Б.Батсайхан, Ж.Баярсайхан, Т.Тунгалаг нарыг тус тус томилсон.

**Төлөөлөн удирдах зөвлөл:**

Техник импорт ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөл нь Хувьцаа эзэмшигчдийн хурлын чөлөөт цагт компанийн удирдлагыг хэрэгжүүлдэг бөгөөд компанийн хувьцаа эзэмшигчдийн эрхийг хамгаалж, тэднийг төлөөлж компанийн “Дүрэм” болон “ТУЗ-ын үйл ажиллагааны журам”-аар олгосон эрх, үүргийн хүрээнд:

1. Компанийн Хувьцаа эзэмшигчдийн хурлаас баталсан шийдвэр, тогтоолыг хэрэгжүүлэх,
2. Компанийн үйл ажиллагааны үндсэн чиглэлийг тогтоох
3. Компанийн үйл ажиллагааг ерөнхий удирдлагаар хангах
4. Компанийн Гүйцэтгэх удирдлагаас хэрэгжүүлж байгаа үйл ажиллагаанд хяналт тавих үүргийг хэрэгжүүлж ажилладаг.

Тайлант хугацаанд компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөл нь 6 хараат болон 3 хараат бус нийт 9 гишүүний бүрэлдэхүүнтэйгээр Компанийн тухай хууль, Компанийн “Дүрэм”, “ТУЗ-ын үйл ажиллагааны журам”-д заасны дагуу

1. Банкнаас зээл авах эрх олгох тухай /2022.01.25. Тогтоол №01/
2. 2022 оны Хувьцаа эзэмшигчдийн хурлыг зарлан хуралдуулах тухай/2022.02.17.Тогтоол №02/
3. 2021 оны Ногдол ашиг хуваарилж олгох эсэх тухай, /2022.02.17. Тогтоол №03/
4. 2021 оны жилийн эцсийн тайланг аудитын компаниар баталгаажуулах зөвшөөрөл олгох тухай /2022.03.24. Тогтоол№04/
5. Охин компани болох япон, монголын хамтарсан хөрөнгө оруулалттай Эм Жэй Агритех ХХК-ийн дүрмийн санд Техник импорт ХК-иас хувь нийлүүлсэн хөрөнгийг нэмэгдүүлэх эсэх тухай /2022.06.15 Тогтоол №05/

асуудлаар 5 удаа хуралдаж ТУЗ-ын гишүүдийн 100 хувийн саналаар асуудлыг шийдвэрлэж тогтоол гарган хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж ажилласан. ТУЗ-ын 5 удаагийн хуралд ТУЗ-ын 9 гишүүн бүгд оролцож 100 хувийн ирцтэйгээр хурлаар хэлэлцсэн асуудлыг хэлэлцэж шийдвэр гаргасан.

ТУЗ-ын гишүүдээс Т.Тунгалаг компанийн хувьцаанаас 17,733 ширхэг хувьцааг эзэмшдэг. 2022 оны ХЭХ-аас сонгогдсон нийт ТУЗ-ын 9 гишүүн, ТУЗ-ын нарийн бичгийн дарга нь компанийн засаглалын сургалтанд хамрагдаж гэрчилгээ авсан.

Мөн компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх хороод нь өөрсдийн эрхлэх чиг үүргийн хүрээнд дараах асуудлаар хуралдаж санал, дүгнэлт гаргасан. Үүнд:

ТУЗ-ын дэргэдэх Нэр дэвшүүлэх хороо нь

1. 2022 оны ХЭХ-аар ТУЗ-ын гишүүдийг сонгож томилохтой холбогдуулан 2021 онд ТУЗ-ын гишүүдээр ажилласан ТУЗ-ын гишүүдийн ажлын үр дүнг хэлэлцэх, дүгнэлт гаргаж ТУЗ-д танилцуулах,
2. 2022 оны ХЭХ-аар ТУЗ-ын гишүүдийг сонгож томилохтой холбоотойгоор ТУЗ-ын гишүүдийг бүртгэн, сонгон шалгаруулалт

хийж ХЭХ-д шууд нэр дэвшүүлэх,

ТУЗ-ын дэргэдэх Аудитын хороо нь

1. 2021 оны компанийн үйл ажиллагааны болон жилийн эцсийн санхүүгийн тайланд дүгнэлт өгөх,
2. Банкнаас зээл авахтай холбогдуулан компанийн дотоод аудитын албаны үйл ажиллагааны явц, байдалтай танилцах, тус албаны тайлан, мэдээлэлтэй уялдуулан компанийн санхүүгийн үйл ажиллагааг үнэлэх, дүгнэлт өгөх,
3. 2021 оны нэгж хувьцаанд ногдол ашиг олгох эсэх талаар дүгнэлт гаргах,
4. Жилийн эцсийн санхүүгийн тайланд аудит хийх компанийг сонгох, гэрээ байгуулах,
5. Компанийн дотоод аудитын албаны үйл ажиллагаанд хяналт тавьж, албанаас гаргаж буй тайлан мэдээллийг үнэлэх, дүгнэлт гаргах,
6. “ТУЗ-ын үйл ажиллагааны журам”, “Мэдээллийн үйл ажиллагааны журам”-д заасны дагуу компанийн засаглалын кодекст заасан мэдээллийг хэрхэн хүргэж байгаад хяналт тавьж дүгнэлт өгөх,

Цалин, урамшууллын хороо нь

1. ISO-9001-2015 чанарын менежментийн тогтолцоог компанид хэрэгжүүлэхтэй холбогдуулан компанийн бүтэц, зохион байгуулалтад өөрчлөлт оруулсны дагуу компанид мөрдөх ажлын үр дүнтэй холбогдсон цалин, урамшууллын бодлогыг тодорхойлж, үр дүнгүнэлэх, Төлөөлөн удирдах зөвлөл нь өөрийн үйл ажиллагааг үр өгөөжтэй, байнгын мэргэшсэн байдлаар явуулах зорилгоор компанийн үйл ажиллагаатай уялдуулан хороодоос өөрсдийн чиглэлийн дагуу гаргасан санал, дүгнэлттэй танилцах, хороодын дүгнэлтийг ТУЗ-ын хурлаар хэлэлцүүлж шийдвэр гаргах, шаардлагатай тохиолдолд компанийн бизнес үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлт, санхүүгийн үйл ажиллагааны явц, байдлын талаар компанийн Гүйцэтгэх удирдлагаас сар тутам ажлын тайлан, мэдээлэл авч хянан холбогдох үүрэг, чиглэлийг өгч ажилласан.

### **3. Компанийн гүйцэтгэх удирдлага**

Тайлант хугацаанд компанийн Гүйцэтгэх удирдлага нь Төлөөлөн удирдах зөвлөлтэй байгуулсан гэрээнд заасан эрх хэмжээний дотор компанийн өдөр тутмын үйл ажиллагааг удирдан зохион байгуулж ажилласан.

Техник импорт ХК-ийн Гүйцэтгэх захирлаар 2006 оноос хойш Дашдондог овогтой Ганцэцэг ажиллаж байна.

Тайлант хугацаанд Техник импорт ХК нь үйл ажиллагаандаа ISO-9001-2015 чанарын удирдлагын тогтолцоог нэвтрүүлэхээр компанийн бүтэц, зохион байгуулалтад өөрчлөлт оруулсан ба дараахь бүтэцтэйгээр үйл ажиллагаагаа зохион байгуулж ажилласан.

1. Гүйцэтгэх захирал
2. Дотоод аудитын алба
3. Захиргаа, хүний нөөцийн алба
4. Дэмжих үйлчилгээний алба
5. Инженер техникийн алба
6. Санхүүгийн алба
7. Бизнес хөгжлийн алба

Компанийн дотоод аудитын алба нь 2012 онд анх байгуулагдаж үйл ажиллагаагаа явуулж эхэлсэн бөгөөд компанийн бүтэц, зохион байгуулалтын дагуу Гүйцэтгэх захирлын шууд удирдлага дор үйл

ажиллагаагаа явуулдаг. Компанийн Гүйцэтгэх захирлын 2022 оны 03 сарын 10-ны өдрийн А-08 тоот тушаалаар “Санхүүгийн дотоод аудитын журам”-ыг шинэчлэн баталж компанийн үйл ажиллагаанд мөрдөн ажиллаж байна.

Дотоод аудитын алба нь Гүйцэтгэх захирлаас өгсөн чиг үүргийн дагуу болон журмаар олгосон чиг үүргийн хүрээнд компанийн үйл ажиллагаанд аудит хийж Гүйцэтгэх удирдлагаас тогтоосон хугацаанд ажлын үр дүнг танилцуулж тайлагнадаг.

2022 оны компанийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаас батлагдсан “2022 оны үйл ажиллагааны бизнес төлөвлөгөө”-ний дагуу компанийн удирдлагаас цемент, мотоцикл, битум, арматур, хүнд даацын дугуйг зах зээлд худалдан борлуулах ажлыг зохион байгуулж ажиллалаа.

Компанийн Гүйцэтгэх захиралд сар бүр олгох цалингийн хэмжээ нь ТУЗ-ын Гүйцэтгэх захиралтай байгуулсан “Компанийн удирдлагыг хэрэгжүүлэх гэрээ”-нд заасны дагуу тогтмол байх ба Төлөөлөн удирдах зөвлөл нь гүйцэтгэх захирлын гэрээгээр хүлээсэн ажлын гүйцэтгэлийн үр дүн, компанийн ХЭХ-аас баталсан тухайн жилийн бизнес төлөвлөгөөг хэрхэн хэрэгжүүлж ажилласныг үндэслэн Гүйцэтгэх захирал түүний удирдлагын багт шагнал, урамшуулал олгох эсэхийг хэлэлцэж шийдвэрлэсэн.

#### Зах зээлийн эрсдэлийн мэдээлэл

Тайлант хугацаанд дэлхий нийтийг хамарсан Ковид-19 цар тахлын нөлөөгөөр дэлхийн улс орнуудад бараа материал, хүнсний бүтээгдэхүүний үнэ нэмэгдсэн нь монгол улсын дотоодын зах зээлд бараа бүтээгдэхүүний үнэ эрс нэмэгдэх шалтгаан болж энэ нь компанийн үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлсөн.Өөрөөр хэлбэл барилгын материалын үнэ өссөнөөс компанийн харилцагч байгууллагуудын худалдан авах чадвар буурах, барилгын материалын нийлүүлэлт /цемент, арматур/ саатах, барилгын ажил тодорхойгүй хугацаагаар зогсох, хойшлогдох, үнийн өсөлт болон гадаад валютын ханшийн өсөлтөөс шалтгаалж компани эргэлтийн хөрөнгийн дутагдалд орох зэрэг гадаад болон дотоод эрсдэлт хүчин зүйлсийг бий болгосон.

Хувьцаа эзэмшигчдийн өмчлөлийн мэдээлэл /5 ба түүнээс дээш хувьцаа эзэмшигчдийн нэрс эзэмшлийн хувь, нийт хувьцаа эзэмшигчдийн тоо/

2022 оны 03 дугаар сарын 15-ны өдөр “Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв” ХХК-иас ирүүлсэн судалгаагаар: Нийт хувьцааны тоо: 1, 446, 755

Хувьцаа эзэмшигчдийн тоо: 462

№	Овог нэр	Хувьцааны төрөл	Эзэмшиж буй хувьцааны тоо /ширхэг/	Эзэмшиж буй хувь
1.	Д.Ганбат	Энгийн	475161	32,84%
2.	Д.Ганцэцэг	Энгийн	455736	31,5%
3.	Г.Содбилэг	Энгийн	480300	33,2%

Үнэт цаас гаргагч нь төсөл хэрэгжүүлэх зорилгоор нийтэд санал болгон хувьцаа гаргасан бол төсөл хэрэгжиж эхэлснээс хойш дуусах хүртэл хугацаанд төслийн хэрэгжилтийн явц болон татан төвлөрүүлсэн хөрөнгийн зарцуулалтын тайлан мэдээлэл

Тайлант хугацаанд төсөл хэрэгжүүлээгүй тул татан төвлөрүүлсэн хөрөнгө байхгүй.

#### Ногдол ашгийн мэдээлэл



Жил бүр компанийн Төлөөлөн удирдах зөвлөл Хувьцаа эзэмшигчдийн хуралд ногдол ашгийн талаарх ТУЗ-ын тогтоол, шийдвэр, ногдол ашгийн тайланг танилцуулж тайлагнадаг.

Тайлант хугацаанд:

- Техник импорт ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөл өөрийн бүрэн эрхийн хүрээнд Компанийн тухай хуулийн 76.1,76.112 дахь заалт, Техник импорт ХК-ийн дүрмийн 7.47, 7.47.12 дахь заалт, “Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны журам”-ын 2.5, 2.5.10-т заасны дагуу 2021 оны ногдол ашиг хуваарилах эсэх асуудлаар 2022 оны 02 дугаар сарын 17-ны өдөр хуралдаж дараахь шийдвэрийг гаргасан. Үүнд:
- 2021 оны компанийн Хувьцаа эзэмшигчдийн нэгж хувьцаанд 500 төгрөгийн ногдол ашиг хуваарилах,
- 2021 оны ногдол ашиг авах эрхтэй хувьцаа эзэмшигчдийг 2022 оны 03 дугаар сарын 10-ны өдрөөр тогтоох,
- Ногдол ашгаа тогтоосон хугацаанд аваагүй Хувьцаа эзэмшигчдийн ногдол ашгийг “Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв” ХХК-ийн дансанд шилжүүлж байршуулах,
- Компанийн тухай хуулийн 46.5-д заасны дагуу ногдол ашгийн талаарх ТУЗ-ын шийдвэр, тогтоолыг холбогдох хуульд заасан хугацаанд Санхүүгийн зохицуулах хороо болон Монголын хөрөнгийн бирж ТӨХК-д хүргүүлсэн.

Техник импорт ХК-ийн 2022 оны 04 дүгээр сарын 11-ний өдрийн Хувьцаа эзэмшигчдийн хурлаас Төлөөлөн удирдах зөвлөлийн 2022 оны 02 дугаар сарын 17-ны өдрийн хурлаас гаргасан шийдвэрийг хэлэлцэж баталсан.

Ногдол ашиг олгох талаар 2022 оны ХЭХ-ын шийдвэрийг хэрэгжүүлэх зорилгоор Техник импорт ХК-ийн удирдлагаас 2021 оны ногдол ашгийг дараах хэлбэрээр компанийн Хувьцаа эзэмшигчдэд олгож, ногдол ашгийн тайланг 2023 оны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд тайлагнасан. Үүнд:

- 2021 оны ногдол ашиг олгох талаар 2022 оны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаас баталж гаргасан тогтоолын дагуу компанийн нийт 1 446 755 ширхэг хувьцаанд 723 377 500 төгрөгийн ногдол ашиг олгохоос 2022 оны 04 дүгээр сарын 11-ний өдөр компанийн 8 хувьцаа эзэмшигчээс ногдол ашгаа авах талаар гаргасан өргөдөл, хүсэлтийг үндэслэн 1 432 282 ширхэг хувьцаанд ногдох 716 141 000 төгрөгийг компани дээрээс олгосон.
- Техник импорт ХК-иас Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв ХХК-тай 2022 оны 04 дүгээр сарын 19-ний өдөр байгуулсан 03/05 тоот “ҮЦТХТ ХХК-иар зуучлуулан ногдол ашиг олгох гэрээ”-ний дагуу ногдол ашгаа аваагүй нийт 454 хувьцаа эзэмшигчийн 14,473 ширхэг хувьцаанд ногдох 6, 873, 050.00 төгрөгийг ҮЦТХТ ХХК-ийн Төрийн банк дахь 341 303 332 956 тоот дансанд 2022 оны 04 дүгээр сарын 26-ны өдөр шилжүүлж байршуулсан.

Дээрх мэдээ, тайлангаас гадна 2022 онд Техник импорт ХК нь Санхүүгийн зохицуулах хорооноос ирүүлсэн “Даалгавар өгөх тухай” албан бичиг, Монголын хөрөнгийн бирж ТӨХК-иас ирүүлсэн “Хамтран ажиллах тухай” албан бичигт заасан хугацаанд дараах компанийн мэдээллийг хүргүүлж ажилласан. Үүнд:

1. Техник импорт ХК-ийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан
2. Техник импорт ХК-ийн 2021 оны ногдол ашиг тараах эсэх тухай ТУЗ-ын шийдвэр, тогтоол
3. Техник импорт ХК-ийн 2022 оны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг хуралдуулах талаар ТУЗ-аас гаргасан шийдвэр, тогтоол, холбогдох баримт материалын хамт
4. Техник импорт ХК-ийн 2022 оны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаас гарсан шийдвэр, хурлын тэмдэглэл, тогтоол, холбогдох баримт материалын хамт

5. Техник импорт ХК-ийн 2021 оны санхүүгийн жилийн эцсийн тайланд хийсэн аудитын компанийн дүгнэлт
6. Техник импорт ХК-ийн 2021 оны жилийн үйл ажиллагааны тайлан
7. Техник импорт ХК-ийн 2022 оны хагас жилийн үйл ажиллагааны тайлан
8. Техник импорт ХК-ийн 2022 оны хагас жилийн санхүүгийн тайлан

Үнэт цаас гаргагчаас тайлант хугацаанд нийгмийн хариуцлагын чиглэлээр хийгдсэн ажлын тайлангийн мэдээлэл

Тайлант хугацаанд компаниас нийгмийн хариуцлагын чиглэлээр дараах ажлуудыг хийж хэрэгжүүлсэн болно. Үүнд:

1. Автозамын түгжрэлийг бууруулахад туслах зорилгоор Баянгол дүүргийн 5-р хороонд байрлах Гурвалжингийн гүүрний доогуур эргэсэн туслах замын голд бетонон хязгаарлагч байрлуулж зохих замын тэмдэг, тэмдэглэгээг хийж өгсөн.
2. Галын аюулаас урьдчилан сэргийлэх зорилгоор Баянгол дүүргийн 5 хороонд галын багаж хэрэгслийг худалдан авч өгсөн.
3. Компанийн нийт ажилчдыг эрүүл мэндийн бүрэн шинжилгээнд хамруулж холбогдох зардлыг компаниас гаргасан.
4. Компанийн 3 ажилтанд байрны урьдчилгаа 30%-ийг олгосон ба компанийн ажилчдыг тогтвор суурьшилтай ажиллуулах, ажлын үр дүн, бүтээмжид суурилсан цалин, урамшууллын хэмжээг шинэчлэн тогтоож хэрэгжүүлэхээр шийдвэрлэсэн.
5. Олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдөр 40 ширхэг хүүхдийн бэлгийг 5-р хороонд оршин суух өнчин болон хагас өнчин хүүхдүүдэд зориулж өгсөн.


Овог, нэр: Д.Ганцэцэг

Овог, нэр: П.Шаравхорол

Албан тушаал: “Техник импорт” ХК-ийн

Албан тушаал: “Лидер экаунт аудит”  
ХХК компанийн гүйцэтгэх захирал

Гүйцэтгэх захирал .....




Мэдээлэл бэлтгэж, хүргүүлсэн этгээдийн гарын үсэг, огноо: 2023.05.30

Овог, нэр: О.Бужинлхам

Албан тушаал: ТУЗ-ын нарийн бичгийн дарга

Гарын үсэг: .....





# “ЛИДЕР ЭКАУНТ АУДИТ” ХХК

2022 оны 3 сарын 27 өдөр

Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 2-р хороо,  
Төмөрчний гудамж - 8, 405 тоот  
Утас: +976 7711-4519

## ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН

### ТЕХНИК ИМПОРТ ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДЭД

#### *Санал дүгнэлт*

Бид Техник импорт ХК-ийн 2022 оны 12 дугаар сарын 31-нээрх санхүүгийн байдлын тайлан, өдрөөр дуусгавар болсон жилийн орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан болон ач холбогдол өндөртэй нягтлан бодох бүртгэлийн бодлогын хураангуйг багтаасан тайлбар тодруулгуудаас бүрдсэн санхүүгийн тайланд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр, Техник импорт ХК -ийн 2022 оны 12 дугаар сарын 31-нээрх санхүүгийн байдал ба уг өдрөөр дуусгавар болсон жилийн санхүүгийн үр дүн ба өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ нь бүхий л материаллаг зүйлсийн хувьд Санхүүгийн тайлагналын олон улсын сандартын дагуу үнэн зөв, бодитой илэрхийлэгдсэн байна.

#### *Санхүүгийн тайлангийн талаар удирдлага болон засаглах удирдлагын хүлээх үүрэг хариуцлага*

Компанийн удирдлага нь эдгээр санхүүгийн тайлангуудыг Санхүүгийн тайлагналын олон улсын сандартын дагуу бэлтгэх, үнэн зөв толилуулах үүрэгтэй. Удирдлагын тодорхойлох энэхүү дотоод хяналт нь санхүүгийн тайланг аливаа алдаа эсвэл залилангийн улмаас үүсч болох материаллаг буруу илэрхийлэлгүй болгоход шаардлагатай байдаг.

Компанийн засаглах удирдлага нь санхүүгийн тайлагналын үйл явцад хяналт тавих үүрэг хариуцлагатай байна.

#### *Санхүүгийн Тайлангийн Аудитад Аудиторын Хүлээх Үүрэг Хариуцлага*

Залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайланг нь бүхэлдээ анги эсэх талаарх үндэслэлтэй нотолгоо олж авах, дүгнэлт бүхий аудиторын тайлан гаргах нь бидний зорилго юм. Үндэслэлтэй нотолгоо гэдэг нь өндөр түвшний нотолгоо боловч АОУС-ын дагуу хийгдсэн аудитаар байгаа материаллаг буруу илэрхийллийг байнга илрүүлдэг гэсэн нотолгоо болохгүй. Буруу илэрхийлэх явдал нь залилан эсвэл алдаанаас үүсч болох ба хэрэв тэр нь дангаараа эсвэл нийтдээ санхүүгийн тайланд үндэслэн гаргасан хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх магадлалтай бол материаллагт тооцогддог.

#### *Бусад*

Энэхүү тайланг Монгол Улсын Компанийн тухай хуулийн 95.1 дүгээр зүйлд заасан хуулийн этгээд болох Техник импорт ХК-ийн хувьцаа эзэмшигчдэд зориулж бэлтгэсэн. Бид энэхүү тайлангийн агуулгын хүрээнд өөр аливаа нэг гуравдагч талын өмнө хариуцлага хүлээхгүй.

ЛИДЕР ЭКАУНТ АУДИТ ХХК-ийн

Захирал

П.Шаравхорол